



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 02 сарын 20 өдөр

Дугаар А/72

Хэрлэн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.1, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны "Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай", "2017 оны төсөв батлах тухай" 02 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх 12 дэд хөтөлбөрийн нээлтийн арга хэмжээг 2017 оны 2 дугаар сарын 24-ний өдөр Чингис хотод зохион байгуулахтай холбогдуулан 14 000 000 /арван дөрвөн сая/ төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

Хоёр. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

Гурав. Хөрөнгө зарцуулахад шаардагдах зардлыг орон нутгийн хөгжлийн сангийн хөтөлбөр, төслийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

01 418

02 Аймгийн Засаг даргын 2017 оны
..... дугаар сарын өдрийн
..... дугаар захирамжийн хавсралт



Хөрөнгө зарцуулалтын төсөв

№	Хөтөлбөрийн зардал	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	LED дэлгэц, пароди хамтлаг	1	5 000 000	5 000 000
2	"Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулга" урлагийн тоглолт	1	1 500 000	1 500 000
3	Телевизийн нэвтрүүлэг	1	3 700 000	3 700 000
4	Шторк	1	800 000	800 000
5	Танилцуулга	50	2 000	100 000
6	12 хөтөлбөрийн логотой самбар	48	10 000	480 000
7	Хөлтэй самбар	12	40 000	480 000
8	Эх бэлтгэл	1	100 000	100 000
9	Шатахуун	1	100 000	100 000
10	Хоол, гарын бэлэг	25	69 600	1 740 000
	Нийт дүн			14 000 000